



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит
Аудитын код: БНА-2019/87/СТА-ТШЗ



Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail, bayankhongor@audit.gov.mn

2019.02.21 № 2/39

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Г БАЯНЛИГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.ЭРДМАА ТАНАА 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянлиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянлиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\Usukhuu\STA-2019\9.Баянлиг ИТХ\4.Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519053

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Эрдмаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, сумын ИТХурал, багийн Иргэдийн Нийтийн хурлыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ИТХ-ын бие даасан үйл ажиллагааг хангах, төлөөлөгчдийн мэдлэг хандлагыг дээшлүүлж, идэвхжүүлэх

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн ““Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acoulous”” програм хангамж ашигладаг байна.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 50907.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1018.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 50835.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 50492.2 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь 2018 онд 50835.2 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 342.9 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 20 мэдээллээс 19 мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,852,178.00	3,010,499.00
33	АВЛАГА	16,769.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	16,769.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,835,409.00	3,010,499.00
351	Түүхий эд материал	330,000.00	330,000.00
35110	Тусгай зориулалттай материал	330,000.00	330,000.00
354	Хангамжийн материал	2,505,409.00	2,680,499.00
35410	Бичиг хэргийн материал	803,409.00	468,499.00
35420	Аж ахуйн материал	1,702,000.00	2,212,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,719,813.81	13,046,370.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,719,813.81	13,046,370.84
392	Биет хөрөнгө	6,719,813.81	13,046,370.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,100,000.00	21,132,142.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-888,888.96	-15,965,435.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,597,670.00	10,667,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,559,758.80	-6,324,296.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,710,843.23	7,410,843.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,240,051.66	-3,874,551.98
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,571,991.81	16,056,869.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,571,991.81	16,056,869.84
51	Засгийн газрын хувь оролцоо	9,571,991.81	16,056,869.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,798,761.00	7,798,761.00
51101	Өмч: - төрийн	7,798,761.00	7,798,761.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,653,521.77	8,138,399.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,653,521.77	1,653,521.77
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	6,484,878.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	119,709.04	119,709.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,571,991.81	16,056,869.84

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	27,329,411.00	57,391,941.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	6,556,741.32
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	6,556,741.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	6,556,741.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	6,551,041.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,329,411.00	50,835,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,531,827.00	50,835,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,531,827.00	50,835,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,797,584.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,797,584.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,847,845.64	50,907,063.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,847,845.64	50,907,063.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,050,261.64	50,364,106.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,331,174.00	38,840,892.00
210101	Үндсэн цалин	17,331,174.00	38,840,892.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,012,029.00	4,661,820.00
210201	Тэтгэврийн даатгал	2,012,029.00	3,108,336.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	388,541.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	310,833.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	77,026.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	777,084.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,862,142.00	3,231,410.00
210401	Бичиг хэрэг	1,018,750.00	817,810.00
210402	Тээвэр, шатахуун	843,392.00	2,181,557.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	232,043.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	480,500.00
210702	Дотоод албан томилолт	00.00	480,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	455,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	455,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	844,916.64	2,694,484.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	844,916.64	1,994,484.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,797,584.00	542,957.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,797,584.00	200,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,797,584.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	342,957.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	342,957.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,481,565.36	6,484,878.03
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,481,565.36	6,484,878.03

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	37,979,211.00	50,840,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	5,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	5,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	5,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,979,211.00	50,835,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,181,627.00	50,835,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,181,627.00	50,835,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,797,584.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,797,584.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	36,042,587.00	49,070,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,042,587.00	49,070,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,245,003.00	50,497,943.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,729,212.00	38,888,658.00
210101	Үндсэн цалин	24,497,070.00	38,888,658.00
210104	Урамшуулал	2,232,142.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,896,143.00	4,597,285.00
210201	Тэтгэврийн даатгал	2,896,143.00	4,597,285.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,691,448.00	2,951,500.00
210401	Бичиг хэрэг	311,800.00	537,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,379,648.00	2,181,557.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	232,043.00
2105	Нормативт зардал	289,200.00	00.00
210502	Хоол, хүнс	289,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	280,000.00
210602	Тавилга	00.00	230,000.00
2107	Томилолт, зочны зардал	619,000.00	680,500.00
210702	Дотоод албан томилолт	619,000.00	480,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,000.00	100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,797,584.00	342,957.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,797,584.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,797,584.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	342,957.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	342,957.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,936,624.00	1,770,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,770,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,770,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,770,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	1,770,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,770,000.00

3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,798,761.00	119,709.04	1,653,521.77	9,571,991.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,798,761.00	119,709.04	1,653,521.77	9,571,991.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,484,878.03	6,484,878.03
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,798,761.00	119,709.04	8,138,399.80	16,056,869.84

3.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,624,163.00	57,043,975.00	50,835,200.00	50,492,243.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,624,163.00	57,043,975.00	50,835,200.00	50,492,243.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,469,907.00	48,889,675.00	50,635,200.00	50,492,243.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,716,700.00	36,328,259.00	38,961,900.00	38,888,658.00
210101	Үндсэн цалин	33,116,700.00	34,096,117.00	38,961,900.00	38,888,658.00
210104	Урамшуулал	3,600,000.00	2,232,142.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,065,600.00	4,003,688.00	4,675,400.00	4,597,285.00
210201	Тэтгэврийн даатгал	4,065,600.00	4,003,688.00	3,149,000.00	4,597,285.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	381,600.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	305,300.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	76,300.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	763,200.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,329,307.00	3,327,228.00	2,945,800.00	2,945,800.00
210401	Бичиг хэрэг	442,300.00	441,800.00	416,800.00	532,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,787,007.00	2,786,428.00	2,185,400.00	2,181,557.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	00.00	00.00	343,600.00	232,043.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	99,000.00	00.00	00.00
2105	Нормативт зардал	719,000.00	709,200.00	00.00	00.00
210502	Хоол, хүнс	719,000.00	709,200.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,218,800.00	2,218,800.00	2,280,000.00	2,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	00.00	280,000.00
210602	Тавилга	2,218,800.00	2,218,800.00	2,280,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,170,500.00	1,105,500.00	672,100.00	680,500.00
210702	Дотоод албан томилолт	1,170,500.00	1,105,500.00	672,100.00	480,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,000.00	97,000.00	100,000.00	100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	97,000.00	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,000.00	110,000.00	100,000.00	100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,150,000.00	1,100,000.00	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	815,425.00	815,430.00	200,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,154,256.00	8,154,300.00	200,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,111,656.00	5,111,700.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,042,600.00	3,042,600.00	200,000.00	00.00

Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,624,163.00	57,043,975.00	50,835,200.00	50,492,243.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,624,163.00	57,043,975.00	50,835,200.00	50,492,243.00
132001	Орон нутгийн төсвөөс	57,624,163.00	57,043,975.00	50,835,200.00	50,492,243.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	03.00	03.00	03.00	03.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	02.00	02.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	01.00	01.00